

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газар



НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНД ТАВИХ ХЯНАЛТЫГ САЙЖРУУЛЖ, БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ КОМИССЫН ГИШҮҮД ДҮРМЭЭ МӨРДӨЖ АЖИЛЛАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.

АУДИТЫН КОД: ХЭА-2025/06-22-ШТА-НА

“УЛСЫН ТӨСВИЙН 2024 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ”-Д ХИЙСЭН НИЙЦЛИЙН АУДИТ

Хэрлэн сум 2025 он



Аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Ж.Ганбаатар

Утас: 70562112 Цахим хаяг: ganbaatarj@audit.gov.mn

Аудитын менежер Д.Оюунтуяа

Утас: 92116773 Цахим хаяг: oyuntuyad@audit.gov.mn

Ахлах аудитор Д.Эрдэнэбилэг

Утас: 92116770 Цахим хаяг: erdenebilegd@audit.gov.mn

Аудитор Т.Алтаншагай

Утас: 92116768 Цахим хаяг: altanshagait@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу: Цахим хуудас: www.audit.mn



Аудитыг гүйцэтгэсэн:

Хэнтий аймаг дахь
Төрийн аудитын газрын
дарга, тэргүүлэх
аудитор Ж.Ганбаатар

Аудитын менежер
Д.Оюунтуяа

Ахлах аудитор:
Д.Эрдэнэбилэг

Аудитор:
Т.Алтаншагай

Аудитын тайлан,
дүгнэлт, зөвлөмжтэй
холбоотой асуудлаар
нэмж тодруулах, асууж
лавлах, холбогдох
саналаа өгөхийг хүсвэл
70562112 дугаарын
утсаар харилцана уу.

Аудитын тайланг УАГ-
ын www.open.audit.mn
цахим хуудаснаас үзнэ
үү.

Хаяг: Хэнтий аймаг
дахь Төрийн аудитын
газар

Хэрлэн сум, 4-р баг,
аймгийн Засаг даргын
Тамгын газрын байр

АГУУЛГА

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл.....	6
БҮЛЭГ 1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд хууль, журамд заасан шаардлага хангасан төсөл, арга хэмжээг төлөвлөөгүй байна.	9
1.1. Шинээр орон нутагт эрх шилжүүлэн хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний 81.8 хувь нь Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөтэй нийцэхгүй байна.	9
1.2. ТЭЗ нар хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг бүрэн тооцож төлөвлөхгүй байна.	9
1.3. Төсөвлөлтийн шаардлагыг хангаагүй 5 төсөл, арга хэмжээг төлөвлөсөн байна.	10
1.4. Тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг төлөвлөсөн байна.	11
БҮЛЭГ 2. Худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулсан байна.	12
2.1. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг батлах, эрх шилжүүлэх, худалдан авах ажиллагааны журмыг сонгох үйл ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулсан байна.	12
2.2 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний тендерийн баримт бичгийг хууль, журамд нийцүүлэн боловсруулжээ.	14
2.3 Худалдан авах ажиллагаанд холбогдох хууль, журам, тендерийн баримт бичигт тусгасан шаардлагыг хангасан гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулсан байна.	15
БҮЛЭГ 3. Барилгын тухай хууль, Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрмийг зөрчин гүйцэтгэл дутуу хөрөнгө оруулалтын 6 төсөл, арга хэмжээг ашиглалтад хүлээн авсан байна.	15
3.1 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний ажлын гүйцэтгэлд үндэслэн хууль журмын дагуу зохиогч, захиалагчийн хяналтын зардлыг бүрэн олгоогүй байна.	15
3.2 Төлөвлөсөн хугацаанд бүрэн дуусаагүй хөрөнгө оруулалтын 7 төсөл, арга хэмжээ байна.	16
3.3 Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс нь хөрөнгө оруулалтын 6 төсөл, арга хэмжээний үүрэг даалгаврын биелэлтийг хяналгүй хууль, дүрмийг зөрчин хүлээж авсан байна.	20
3.4 Хэрэгжиж дууссан төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон 30.5 тэрбум төгрөгийн хөрөнгийг бүртгэлд тусгаагүй байна.	22
ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ:.....	24
ДҮГНЭЛТ:	25
ЗӨВЛӨМЖ:	26

ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2025 оны 04 дугаар сарын 18

Дугаар А/17

Чингис хот

Г Нийцлийн аудитын тайлан Т
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 29 дүгээр зүйлийн 29.4, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2023 оны А/102 дугаар тушаалаар батлагдсан “Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудиторт шилжүүлэх эрх”-ийн 1.4 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. “Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт” нийцлийн аудитын тайланг баталгаажуулсугай.

2. Аудитын тайланг Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газар, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, аймгийн Засаг дарга, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, Худалдан авах ажиллагааны газар, Орон нутгийн өмчийн газарт тус тус хүргүүлэхийг ахлах аудитор /Д.Эрдэнэбилэг/-т үүрэг болгосугай.

3. Аудитаар өгсөн албан шаардлагын биелэлтийг тогтоосон хугацаанд, зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасан хугацаанд, түүний биелэлтийг 2025 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн дотор ирүүлэхийг аймгийн Засаг дарга /Д.Аюурбуны/, аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга /Б.Сүнгээ/ нарт тус тус зөвлөсүгэй.

4. Аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцон ажиллахыг аудитор /Г.Алтаншагай/-т даалгасугай.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер (Д.Оюунтуяа)-д үүрэг болгосугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.ГАНБААТАР

232501017

	ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ЗГ	Засгийн газар
ЗГХЭГ	Засгийн газрын хэрэг эрхлэх газар
БХБЯ	Барилга хот байгуулалтын яам
БОУАӨЯ	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам
БСШУСЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
ЦХХХС	Цахим хөгжил харилцаа холбооны сайд
ХЗДХС	Хууль зүй, дотоод хэргийн сайд
БОАЖС	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
ХА	Харьцуулалтын арга
НТШ	Нээлттэй тендер шалгаруулалт
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
УЦУОШГ	Ус цаг уур орчны шинжилгээний газар
ГНАГ	Гүйцэтгэл нийцлийн аудитын газар
НА	Нийцлийн аудит
БЦГ	Байгалийн цогцолборт газар

Дүрслэлийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл 1	Эрх шилжүүлсэн 15 төсөл, арга хэмжээний ангилал, салбар	7
Дүрслэл 2	Эрх шилжсэн төсөл, арга хэмжээг оноор	12
Дүрслэл 3	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл арга хэмжээг хугацаанд нь хэрэгжүүлсэн эсэх	16
Дүрслэл 4	Хэрлэн сумын 1, 2 дугаар багийн иргэдтэй хийсэн үр дүн	21
Дүрслэл 5	Иргэдээс авсан санал асуулгын дүн	22

Хүснэгтийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд тусгаагдаагүй төсөл, арга хэмжээ	8
Хүснэгт 2	Төлөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээ	10
Хүснэгт 3	Хэрэгжиж дууссан төсөл, арга хэмжээний өмчлөлд шилжих жагсаалт	10
Хүснэгт 4	Эрх шилжүүлсэн шийдвэр	12
Хүснэгт 5	ХАА-ны журам сонгох, тендер шалгаруулалтын дугаар	13
Хүснэгт 6	Гэрээ дүгнэсэн эсэх жагсаалт	19
Хүснэгт 7	Үүрэг даалгаврын биелэлтийг хяналгүй хүлээн авсан төсөл, арга хэмжээний жагсаалт	20

Зургийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Зураг 1	Шинэ хөдөө төслөөр олгосон тракторын зураг	11
Зураг 2	Биндэр сумын 200 хүүхдийн цэцэрлэгийн барилгын зураг	16
Зураг 3	Хужхан гол усны урсац сайжруулах усан сангийн зураг	16
Зураг 4	Хэрлэн сумын гэр хорооллын инженерийн шугам сүлжээний ажлын зураг	17
Зураг 5	Бэрх дотор 4.1 км замын зураг	17
Зураг 6	Мөрөн гол усны урсац сайжруулах усан сангийн зураг	18
Зураг 7	Шинэ хөдөө төслийн тоног төхөөрөмжийн зураг	18

	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл
Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2024 оны 05 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2024 оны А/108 дугаар тушаалыг тус тус үндэслэн нийцлийн аудитыг гүйцэтгэлээ.
Аудитын зорилт	Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилтэд аудит хийж, дүгнэлт өгч, зөвлөмж боловсруулан дүнг Улсын Их Хурал болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэгдлээ. Уг зорилгыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд: • <i>Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд хууль, журамд заасан шаардлага хангасан төсөл, арга хэмжээг төлөвлөсөн эсэх;</i> • <i>Хөрөнгө оруулалтаар төлөвлөсөн төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулсан эсэх;</i> • <i>Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хууль журмын дагуу санхүүжүүлж, хугацаанд нь гүйцэтгүүлэн бүртгэлд тусгасан эсэх.</i>
Аудитын хамарсан хүрээ	Төсвийн ерөнхийлөн захирагчаас орон нутагт эрх шилжүүлсэн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгасан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаа, санхүүжилт, хэрэгжилтийг зохион байгуулсан аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч, аймгийн Худалдан авах ажиллагааны газар, Орон нутгийн өмчийн газар, Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар зэрэг байгууллагыг хамруулан төсөл, арга хэмжээний төлөвлөлтийн баримт бичиг, ажлын даалгавар, ТЭЗҮ, зураг төсөл, магадлалын ерөнхий дүгнэлт, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, олгосон санхүүжилт, төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд аудитыг хийлээ.
Аудитын хязгаарлалт	
Аудитын арга зүй,	Аудитыг АДБОУС 4000-4200, Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Тулгуур зарчим”, MNS 6817-6:2020 “Нийцлийн аудитын зарчим”, MNS 6817-8:2020 “Нийцлийн аудитын стандарт”, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах нотлох баримтыг цуглуулж, дүн шинжилгээ хийх, харьцуулах, тулган баталгаажуулах, түүвэрлэн хянах зэрэг судалгааны арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.
Шалгуур үзүүлэлт	Аудитад дараах шалгуур үзүүлэлтийг ашиглав. Үүнд: • Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, • Төсвийн тухай хууль,

	• Төрийн хэмнэлтийн тухай хууль, • Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, • Барилгын тухай хууль, • Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, • Засгийн газрын 2021 оны 160 дугаар, 2023 оны 278 дугаар тогтоолоор тус тус баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”, • Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоол • Сангийн сайдын 2021 оны 102 дугаар тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”, • Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар баталсан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлж, эрэмбэлэх үйл ажиллагааны журам болон холбогдох аргачлалууд”, • Барилгын, хот байгуулалтын сайдын 2019 оны 108 дугаар тушаалаар баталсан “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм” • Барилга хот байгуулалтын сайдын “Барилгын захиалагчийн хяналтын талаар авах зарим арга хэмжээний тухай” 2022 оны 83 дугаар тушаалын • Батлагдсан зураг төсөв, ТЭЗҮ, магадлалын ерөнхий дүгнэлт, ажил гүйцэтгэх гэрээ болон бусад холбогдох эрх зүйн актууд,
Аудитын бүрэлдэхүүн, хугацаа	Аудитыг аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Ж.Ганбаатар хянан удирдаж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер Д.Оюунтуяа хэрэгжүүлж, аудитыг ахлах аудитор Д.Эрдэнэбилэг, аудитор Т.Алтаншагай нар 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдрөөс 04 дүгээр сарын 20-ны өдөр хүртэл хугацаанд гүйцэтгэв.
Хүндрэл бэрхшээл	


ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн хоёрдугаар хавсралтаар 27 төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад хамаарах өмнөх оноос үргэлжлэн хэрэгжих 607, тухайн оноос эхлэн хэрэгжих 712, нийт 11,579.7 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 1319 төсөл, арга хэмжээг 3,828.6 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэхээр баталжээ.

Үүнээс орон нутагт эрх шилжүүлсэн өмнөх оноос үргэлжлэн хэрэгжих 4, тухайн онд хэрэгжиж эхлэх 11, нийт 86.6 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 15 төсөл, арга хэмжээг 56.8 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан байна.

Орон нутагт эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээний нийт санхүүжилтийн 33 хувийг 5 барилга, байгууламж барихад, 33 хувийг 5 их засварт зарцуулахаар тусгажээ. Мөн нийт 15 төсөл, арга хэмжээний 11 төсөл, арга хэмжээг 2024 онд хэрэгжүүлж дуусахаар төлөвлөсөн байна.

Дүрслэл 1. Эрх шилжүүлсэн 15 төсөл, арга хэмжээний ангилал, салбар



Эрх шилжүүлсэн 15 төсөл, арга хэмжээнээс Цэнхэр, Мөрөнгийн голын урсцыг сайжруулах усан сангийн төсөл, арга хэмжээ нь 2 багцад задарч нийт 16 ажил болсон байна. Үүнээс худалдан авах ажиллагааны шалгаруулалтын үед материал ирүүлээгүй шалтгаанаар 1 их засварын ажил хэрэгжээгүй байна. Үлдсэн 15 төсөл, арга хэмжээнээс 3 төсөл, арга хэмжээ нь он дамжин хэрэгжихээр төлөвлөгдсөн байна.

БҮЛЭГ 1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд хууль, журамд заасан шаардлага хангасан төсөл, арга хэмжээг төлөвлөөгүй байна.

1.1. Шинээр орон нутагт эрх шилжүүлэн хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний 81.8 хувь нь Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөтэй нийцэхгүй байна.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулиар батлагдсан Төсвийн ерөнхийлөн захирагчаас орон нутагт эрх шилжүүлсэн өмнөх оноос үргэлжлэн хэрэгжих 4, тухайн онд хэрэгжих 11, нийт 86.6 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 15 төсөл, арга хэмжээнээс Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд тусгагдсан өмнөх оноос үргэлжлэн хэрэгжиж байгаа 2, тухайн онд хэрэгжиж эхэлсэн 2 нийт 4 төсөл арга хэмжээ байна.

Шинээр тухайн онд хэрэгжиж эхэлсэн 11 төсөл, арга хэмжээнээс Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд тусгаагдаагүй дараах 9 арга хэмжээ байна.

Хүснэгт 1. Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд тусгаагдаагүй төсөл, арга хэмжээ

№	Төсөл, арга хэмжээ	Хуулиар батлагдсан санхүүжих дүн	Ангилал
1	Иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилга /Хэнтий, Мөрөн сум/	1,057.8	Барилга, байгууламж
2	Цэнхэр, Мөрөнгийн голын урсац сайжруулах усан сан /Хэнтий/	800.0	Барилга, байгууламж
3	Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төсөл /Хэнтий/	1,914.5	Тоног төхөөрөмж
4	Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төсөл /Завхан, Өвөрхангай, Хэнтий/	150.0	Тоног төхөөрөмж
5	Хэнтий аймгийн цагдаагийн газрын өргөтгөлийн барилгын их засвар	45.9	Их засвар
6	Хамгаалалтын захиргааны барилгын засвар /Онон Балжийн БЦГ/	19.9	Их засвар
7	Хамгаалалтын захиргааны авто гаражийн ажил /Гутайн даваа-Хөмүүл голын эхийн БЦГ/	30.0	Их засвар
8	Цаг уурын өртөөний барилгын их засвар /Хэнтий, Дэлгэрхаан, Хэрлэн Баян-Улаан/	45.0	Их засвар
9	Цаг уурын өртөөний барилгын их засвар /Хэнтий, Өмнөдэлгэр/	45.0	Их засвар

Хүснэгтэд дурдсан Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд тусгаагдаагүй 9 төсөл, арга хэмжээний 88.8 хувь нь төсвийн ерөнхийлөн захирагч буюу сайд нарын багцаас орон нутагт эрх шилжүүлэн хэрэгжүүлсэн 1 барилга байгууламж, 2 тоног төхөөрөмж, 5 их засварын ажил байна. 1 барилга байгууламжийн ажлыг аймгийн ТЕЗ-аас Сангийн яаманд хүргүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалтад тусгагдсан арга хэмжээ байна.

1.2. ТЕЗ нар хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг бүрэн тооцож төлөвлөхгүй байна.

Хэнтий аймгийн Засаг даргын 2023.08.07-ны өдрийн 9/1682 тоот албан бичгээр 2024 оны Улсын төсвийн хөрөнгө оруулалтад тусгуулах 47 санал хүргүүлсэн байна.

Дээрх хүргүүлсэн саналаас 2024 оны төсвийн тухай хуульд 21 төсөл, арга хэмжээг баталсан бөгөөд орон нутгаас санал хүргүүлээгүй, Төсвийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.3-д заасан эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлын тооцоолол хийгдээгүй Шинэ хөдөө, Цэнхэр- Мөрөнгийн голын урсцыг сайжруулах усан сангийн гэсэн 2 төсөл арга хэмжээг нэмж баталсан байна.

Ийнхүү нэмж баталсан нь Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журмын 2.2.1.¹, 2.2.2.² заалтуудтай нийцэхгүй байна.

ХХААХҮЯ, БОУАӨЯ-ны төсвийн ерөнхийлөн захирагч нар хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ хэрэгжих тухайн орон нутгийн санал, Төсвийн тухай хуульд заасан эдийн засаг, нийгмийн ач холбогдол, орон нутгийн хөгжлийн хэрэгцээ зэргийг тооцон хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөх шаардлагатай байна.

1.3. Төсөвлөлтийн шаардлагыг хангаагүй 5 төсөл, арга хэмжээг төлөвлөсөн байна.

Барилгын тухай хуулийн 4.1.26-д "гүйцэтгэлийн зураг" гэж батлагдсан зураг төслийг зохиогчийн зөвшөөрлөөр өөрчилж, эрх бүхий этгээдийн баталгаажуулсан барилгын ажлын зураг төслийг Засгийн газрын 2019 оны 108 дугаар тогтоолоор батлагдсан “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм”-ийн 3.6. “Барилгын тухай хуулийн 4.1.27-д заасан загвар зургийг архитектур төлөвлөлтийн даалгавар болон зураг төслийн даалгаврыг үндэслэн боловсруулах бөгөөд аймаг, нийслэлийн ерөнхий архитектор батална” гэж заасны дагуу төсөл, арга хэмжээний ажлын тоо хэмжээг тодорхойлоогүй, зардлын тооцоолол хийгдээгүй, магадлагдсан төсөвгүй 5 төсөл, арга хэмжээ байна.

Хүснэгт 2. Төлөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээ

№	Төсөл, арга хэмжээ	Ажлын тоо хэмжээ эсэх	Батлагдсан зурагтай эсэх	Батлагдсан төсөвтэй эсэх	Зардлын тооцоолол хийгдсэн эсэх
1	Цэнхэр /Хужхан/ голын урсац сайжруулах усан сан	Тийм	Тийм	Тийм	Үгүй
2	Сумын төвийн шинэчлэл /Хэнтий, Биндэр сум/	Үгүй	Тийм	Тийм	Үгүй
3	Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төсөл /Хэнтий/	Тийм	Тийм	Тийм	Үгүй
4	Орон нутгийн хөгжлийг дэмжих “Шинэ хөдөө” төсөл /Завхан, Өвөрхангай, Хэнтий/	Үгүй	Тийм	Тийм	Үгүй

¹ 2.2.1.1 “Төсөл, арга хэмжээний саналыг холбогдох хууль, журам болон аргачлалд заасан шалгуур үзүүлэлтээр үнэлэн, эрэмбэлэх, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх санхүүжилтийн эх үүсвэрийг оновчтой тогтоох”,

² 2.2.2.2 “Төсөл, арга хэмжээний саналд энэ журамд заасны дагуу судалгаа хийж, эрэмбэлэн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх нэн тэргүүний ач холбогдолтой төсөл, арга хэмжээнүүдийг тодорхойлох, жагсаалт гаргах”

5	Үүрэн холбооны сүлжээ /Хэнтий, Норовлин, Галшар, Батноров, Биндэр, Баян-Адарга, Дадал, Дархан, Баянмөнх сум/	Тийм	Холболтын зурагтай	Үгүй	Тийм
---	--	------	--------------------	------	------

Үүрэн холбооны сүлжээ ажил нь холболтын зураг, төсөвтэй бөгөөд төсвийг магадлалаар баталгаажуулаагүй. Тус төсөл хэрэгжих 8 сумын газар зохион байгуулалтын 2024 оны төлөвлөгөөнд тусгагдаагүйгээс газрын зөвшөөрөл олгогдоогүй байна. Үүнээс шалтгаалж төсвийг магадлалаар баталгаажуулах ажил хийгдээгүй байна.

1.4. Тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг төлөвлөсөн байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлд нийцүүлэн, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөсөн байна.

Хэнтий аймгийн орон нутгийн өмчийн газрын 2025 оны 1 сарын 7-ны өдрийн 3/39 дугаар албан бичгээр 2024 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн барилга, тоног төхөөрөмжийг данс бүртгэлд тусгах жагсаалтыг хүргүүлсэн байна.

Хүснэгт 3. Хэрэгжиж дууссан төсөл, арга хэмжээний өмчлөлд шилжих жагсаалт

№	Төсөл, арга хэмжээ	Өмчлөлд шилжих байгууллага
1	Хэнтий аймгийн цагдаагийн газрын өргөтгөлийн барилгын их засвар	Хэнтий аймгийн Цагдаагийн газар
2	Цэцэрлэгийн барилга, 200 ор /Хэнтий, Биндэр сум/	Биндэр сумын Цэцэрлэг
3	Сургуулийн барилга, 640 суудал /Хэнтий, Өмнөдэлгэр сум/	Өмнөдэлгэр сумын ерөнхий боловсролын сургууль
4	Хатуу хучилттай авто зам, 4.1 км /Хэнтий, Батноров сум, Бэрх тосгон/	Бэрх тосгоны хот тохижилт
5	Цэнхэр /Хужхан/ голын урсац сайжруулах усан сан	Цэнхэрмандал сумын ЗДТГ
6	Сумын төвийн шинэчлэл /Хэнтий, Биндэр сум/	Биндэр тохижилт үйлчилгээ
7	Гэр хорооллын инженерийн шугам сүлжээ /Хэнтий, Хэрлэн сум/	Хэнтий ус ХХК
8	Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төсөл /Хэнтий/	Сумдын ЗДТГ
9	Орон нутгийн хөгжлийг дэмжих “Шинэ хөдөө” төсөл /Завхан, Өвөрхангай, Хэнтий/	Биндэр, Норовлин, Баянхутаг сумдын ЗДТГ
10	Цаг уурын өртөөний барилгын их засвар /Хэнтий, Дэлгэрхаан, Хэрлэн Баян-Улаан/	Аймгийн УЦУОШГ
11	Цаг уурын өртөөний барилгын их засвар /Хэнтий, Өмнөдэлгэр/	Аймгийн УЦУОШГ
12	Хамгаалалтын захиргааны барилгын засвар /Онон Балжийн БЦГ/	Онон Балжийн БЦГ-ын хамгаалалтын захиргаа

Орон нутгийн хөгжлийг дэмжих “Шинэ хөдөө” төслийн хүрээнд 9 суманд олгогдсон 9 том оврын, 3 жижиг оврын тракторуудыг сумдын ЗДТГ-ын данс бүртгэлд тусгасан байна.

Дагалдах хөдөө аж ахуйн 658.0 сая төгрөгийн 23 нэр төрлийн, 27 ширхэг тоног төхөөрөмжийг холбогдох сумдад /Баян-Овоо, Баянхутаг, Биндэр, Бор-Өндөр, Мөрөн, Норовлин, Хэрлэн, Цэнхэрмандал сум, Бэрх тосгон/ хүлээлгэж өгөлгүй аймгийн нөөцийн хашаанд хадгалагдаж байна.

Зураг 1. Шинэ хөдөө төслөөр олгосон тракторын зураг



Аудитын хүрээнд Биндэр суманд талбарт ажиллах үеэр “Шинэ хөдөө” төслийн хүрээнд олгогдсон 150 морины хүчин чадалтай 122.0 сая төгрөгийн 1 ширхэг трактор хаана байгаа нь тодорхойгүй нөхцөл байдал үүссэнийг аудитын явцад тодруулж зөрчлийг арилгасан.


”

БҮЛЭГ 2. Худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулсан байна.

2.1. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг батлах, эрх шилжүүлэх, худалдан авах ажиллагааны журмыг сонгох үйл ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулсан байна.

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 11 сарын 22-ны 409 дүгээр тогтоолоор баталсан 2024 оны төсвийн хөрөнгөөр аймаг нийслэлд эрх шилжүүлэн хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалтад Үүрэн холбооны сүлжээ арга хэмжээ тусгагдаагүй байна. ЦХХХ-ны сайдын 2023 оны 12 сарын 20-ны А/133 тушаалаар тус хөрөнгө оруулалтын арга хэмжээг орон нутагт эрх шилжүүлэн хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн байна.

Дүрслэл 2. Эрх шилжсэн төсөл, арга хэмжээг оноор



Түлхүүр гардуулах нөхцөлөөр 2014 онд хэрэгжүүлж эхэлсэн Биндэр сумын төвийн шинэчлэл төслийн эрх шилжүүлсэн шийдвэр тодорхойгүй байна.

Хүснэгт 4. Эрх шилжүүлсэн шийдвэр

№	Төсөл, арга хэмжээ	Эрх шилжүүлсэн шийдвэр	
		Дугаар	Огноо
1	Сургуулийн барилга, 640 суудал /Хэнтий, Өмнөдэлгэр сум/	БСШУС	2020.02.06 1а/734
2	Цэцэрлэгийн барилга, 200 ор /Хэнтий, Биндэр сум/	БШУС	2021.12.08 А/430

3	Хатуу хучилттай авто зам, 4.1 км /Хэнтий, Батноров сум, Бэрх тосгон/	ЗГ	2023.11.22 409
4	Цэнхэр, Мөрөнгийн голын урсац сайжруулах усан сан /Хэнтий/	ЗГ	2023.11.22 409
5	Иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилга /Хэнтий, Мөрөн сум/	ЗГ ЗГХЭГ	2023.11.22 409 2024.01.30 11
6	Гэр хорооллын инженерийн шугам сүлжээ /Хэнтий, Хэрлэн сум/	БХБС	2021.12.10 267
7	Үүрэн холбооны сүлжээ /Хэнтий, Норовлин, Галшар, Батноров, Биндэр, Баян-Адарга, Дадал, Дархан, Баянмөнх сум/	ЦХХХС	2023.12.20 A/133
8	Сумын төвийн шинэчлэл /Хэнтий, Биндэр сум/	БХБЯ	2024.04.24 08/1335
9	Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төсөл /Хэнтий/	ЗГ ХХААХҮС	2023.11.22 409 2024.01.11 A/14
10	Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төсөл /Завхан, Өвөрхангай, Хэнтий/	ЗГ ХХААХҮС	2023.11.22 409 2024.01.11 A/14
11	Цаг уурын өртөөний барилгын их засвар /Хэнтий, Дэлгэрхаан, Хэрлэн Баян-Улаан/	БОАЖС	2024.01.19 A/38
12	Цаг уурын өртөөний барилгын их засвар /Хэнтий, Өмнөдэлгэр/	БОАЖС	2024.01.19 A/38
13	Хамгаалалтын захиргааны авто гаражийн ажил /Гутайн даваа-Хөмүүл голын эхийн БЦГ/	БОУАӨЯ	Хэрэгжээгүй
14	Хэнтий аймгийн цагдаагийн газрын өргөтгөлийн барилгын их засвар	ХЗДХС	2023.12.18 A/419
15	Хамгаалалтын захиргааны барилгын засвар /Онон Балжийн БЦГ/	БОУАӨЯ	2024.11.11 24/442 гэрээ

Эрх шилжсэн барилга байгууламжийн 8 төсөл, арга хэмжээнээс НТШ-аар 7, түлхүүр гардуулах нөхцөлтэйгөөр 1 төсөл арга хэмжээг, тоног төхөөрөмжийн 2 ажлыг НТШ болон харьцуулалтын аргаар, их засварын 5 ажлын 4-ийг харьцуулалтын аргаар, шууд худалдан авалтын гэрээгээр 1 ажлын худалдан авах ажиллагааг тус тус зохион байгуулсан байна.

Биндэр сумын “Сумын төвийн шинэчлэл” төслийг 2005 оны 12 сарын 1-ний өдөр батлагдсан 2024 оны 1 сарын 1-ний өдрөөс хүчингүй болсон “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 8.10. “Зураг төсөл, барилга угсралт, тохируулгын ажлыг түлхүүр гардуулах гэрээгээр гүйцэтгүүлэхээр бүхэлд нь тендер зарлаж болно” гэж заасны дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна.

Гутайн даваа-Хөмүүл голын эхийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны авто гаражийн худалдан авах ажиллагааг 2024 оны 5 сарын 21-ний өдөр зарлагдсан боловч тендер шалгаруулалтад материал ирүүлгүй тул хэрэгжээгүй байна.

Хүснэгт 5. ХАА-ны журам сонгох, тендер шалгаруулалтын дугаар

№	Төсөл, арга хэмжээ	Анхны	Худалдан авах ажиллагаа	
		төсөвт өртөг /сая төгрөгөөр/	ХАА-ны журам сонгох	Тендер шалгаруулалтын дугаар
Барилга байгууламж				
1	Сургуулийн барилга, 640 суудал /Хэнтий, Өмнөдэлгэр сум/	4000.0	НТШ	БСШУСЯ/202001247
2	Цэцэрлэгийн барилга, 200 ор /Хэнтий, Биндэр сум/	4154.0	НТШ	БШУЯ/202212068
3	Хатуу хучилттай авто зам, 4.1 км /Хэнтий, Батноров сум, Бэрх тосгон/	6172.7	НТШ	ЗТХЯ/20240101063
4	Цэнхэр, Мөрөнгийн голын урсац сайжруулах усан сан /Хэнтий/	800.0	НТШ	БХБЯ/20240101047
5	Иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилга /Хэнтий, Мөрөн сум/	3526.1	НТШ	ЗГХЭГ/20240101010
6	Гэр хорооллын инженерийн шугам сүлжээ /Хэнтий, Хэрлэн сум/	29950.0	НТШ	БХБЯ/202212017
7	Үүрэн холбооны сүлжээ /Хэнтий, Норовлин, Галшар, Батноров, Биндэр, Баян-Адарга, Дадал, Дархан, Баянмөнх сум/	2924.7	НТШ	ЦХХХЯ/20240101004
8	Сумын төвийн шинэчлэл /Хэнтий, Биндэр сум/	5000.0	Түлхүүр гардуулах нөхцөл	2014 онд
Тоног төхөөрөмж				
9	Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төсөл /Хэнтий/	1914.5	НТШ	ХХААХҮЯ/20240102037
10	Орон нутгийн хөгжлийг дэмжих “Шинэ хөдөө” төсөл /Завхан, Өвөрхангай, Хэнтий/	150.0	ХА	ХХААХҮЯ/20240202222 ХХААХҮЯ/20240202224 ХХААХҮЯ/20240202223
Их засвар				
11	Цаг уурын өртөөний барилгын их засвар /Хэнтий, Дэлгэрхаан, Хэрлэн Баян-Улаан/	45.0	ХА	БОАЖЯ/20240201056
12	Цаг уурын өртөөний барилгын их засвар /Хэнтий, Өмнөдэлгэр/	45.0	ХА	БОАЖЯ/20240201057
13	Хамгаалалтын захиргааны авто гаражийн ажил /Гутайн даваа-Хөмүүл голын эхийн БЦГ/	30.0	ХА	БОАЖЯ/20240201031
14	Хэнтий аймгийн цагдаагийн газрын өргөтгөлийн барилгын их засвар	45.9	ХА	ХЗДХЯ/20240201022
15	Хамгаалалтын захиргааны барилгын засвар /Онон Балжийн БЦГ/	19.9	Шууд худалдан авалт	

2.2 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний тендерийн баримт бичгийг хууль, журамд нийцүүлэн боловсруулжээ.

Аймгийн Засаг даргад хэрэгжүүлэх эрхийг шилжүүлсэн 13 төсөл арга хэмжээ, байгууллагад эрхийг шилжүүлсэн 2 ажлын тендерийн баримт бичгийг МУ-ын Сангийн

сайдын 2013 оны 5 сарын 31-ний өдрийн 125 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын дагуу 13 төсөл, арга хэмжээний тендерийн баримт бичгийг боловсруулсан байна.

Хамгаалалтын захиргааны барилгын засвар /Онон Балжийн БЦГ/-ын ажлыг 19.9 сая төгрөгийн төсөвт өртөгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн нь Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 02 дугаар тогтоолоор баталсан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар 20.0 сая төгрөгт хүрээгүй тул шууд худалдан авах гэрээ байгуулсан байна.

2.3 Худалдан авах ажиллагаанд холбогдох хууль, журам, тендерийн баримт бичигт тусгасан шаардлагыг хангасан гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулсан байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Засгийн газрын 2019 оны 108 дугаар тогтоолоор батлагдсан “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм”, 2023 оны 278 тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-д нийцүүлэн тендерийн баримт бичигт тусгагдсан шаардлагыг хангасан гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчаас орон нутагт эрх шилжүүлэн хэрэгжүүлсэн 19.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Хамгаалалтын захиргааны барилгын засвар /Онон Балжийн БЦГ/-ын ажлыг Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 02 дугаар тогтоолоор баталсан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаарт заасан 20.0 сая төгрөгийн дээд хязгаарт хүрээгүй тул БОУАӨЯ, гүйцэтгэгч “Юни Сервис тотал” ХХК нь 2024 оны 11 сарын 11-ний өдөр шууд худалдан авах гэрээ байгуулсан байна. Энэ ажлыг орон нутагт шууд эрх шилжүүлэн хэрэгжүүлсэн гэж үзэх үндэслэлгүй байна.

Онон Балжийн БЦГ-ын хамгаалалтын захиргаанаас тус ажлын хүрээнд 2024 оны 12 сарын 30 өдрийн А/33 тушаалаар шууд худалдан авалтын 24/442 дугаартай гэрээний дагуу нийлүүлж байгаа ZOTA “Тополь-М” загварын нам даралтын зуухыг хүлээн авах ажлын хэсгийг байгуулж хүлээн авч оролцсон байна.

БҮЛЭГ 3. Барилгын тухай хууль, Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрмийг зөрчин гүйцэтгэл дутуу хөрөнгө оруулалтын 6 төсөл, арга хэмжээг ашиглалтад хүлээн авсан байна.

3.1 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний ажлын гүйцэтгэлд үндэслэн хууль журмын дагуу зохиогч, захиалагчийн хяналтын зардлыг бүрэн олгоогүй байна.

Төсөл, арга хэмжээг гүйцэтгэгч байгууллагын ажлын гүйцэтгэлд үндэслэн тухайн онд санхүүжих төсвийн хүрээнд тухай бүр санхүүжилтийг олгож байсан боловч зураг, төсөл зохиогч болон захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэгч байгууллагын хяналтын зардлыг бүрэн олгоогүй байна.

Төсвийн тухай хуулийн 7.7.-д “...төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ” гэж заасны дагуу ТЭЗ-ийн /сайд нарын/ ерөнхий данс руу төвлөрүүлэх үлдэгдлийг аймгийн ерөнхий данс руу төвлөрүүлж төсвийн тухай хуулийн тус заалтыг хэрэгжүүлээгүй байна.


Барилга хот байгуулалтын сайдын “Барилгын захиалагчийн хяналтын талаар авах зарим арга хэмжээний тухай” 2022 оны 83 дугаар тушаалын 2.1.4. “Барилга байгууламжийн захиалагчийн хяналтын зардлыг гүйцэтгэгч байгууллагын дансанд бүрэн шилжүүлэх, хяналтын зардлыг зориулалт бусаар захиран зарцуулахгүй байх” заалтыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Аймгийн Засаг даргад хэрэгжүүлэх эрхийг шилжүүлсэн Сургуулийн барилга, 640 суудал /Хэнтий, Өмнөдэлгэр сум/-ийн захиалагчийн хяналтын 5,187,478 төгрөг, Цэнхэр, Мөрөнгийн голын урсац сайжруулах усан сан /Хэнтий/ зохиогчийн хяналтын 1,837,363 төгрөг, захиалагчийн хяналтын 978,763 төгрөг, Хатуу хучилттай авто зам, 4.1 км /Хэнтий, Батноров сум, Бэрх тосгон/-ийн захиалагчийн хяналтын 78,830,094 төгрөг, Гэр хорооллын инженерийн шугам сүлжээ /Хэнтий, Хэрлэн сум/-ний захиалагчийн хяналтын 81,639,171 төгрөгийн зардлыг захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэгч байгууллагад шилжүүлэлгүй аймгийн нэр заагдаагүй бусад орлогын дансанд төвлөрүүлсэн байна.

3.2 Төлөвлөсөн хугацаанд бүрэн дуусаагүй хөрөнгө оруулалтын 7 төсөл, арга хэмжээ байна.

Барилга байгууламжийн 8 төсөл, арга хэмжээний /Цэнхэр, Мөрөн голын урсац сайжруулах усан сангийн ажил багц-1, багц-2/ 9 ажлын 7 нь гэрээнд заасан хугацаанд бүрэн дуусаагүй байна.

Дүрслэл 3. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл арга хэмжээг хугацаанд нь хэрэгжүүлсэн эсэх



“Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4.7.5.³-д заасны дагуу гэрээний хугацааг тогтоож

³ Гэрээний хугацааг тухайн жилийн төсвийн тухай хуулиар баталсан эхлэх, дуусах хугацааны дагуу гэрээнд тусгах бөгөөд тухайн төслийн санхүүжилт хийгдэж дуусах хүртэл гэрээний дуусах хугацаа хүчинтэй байна;

байгаа нь төсөл, арга хэмжээг ашиглалтад хүлээн авах хугацаа хойшлох гол шалтгаан болж байна.

Энэ шалтгаан нь “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”-ийн 8.1-д заасан комиссын үүрэг даалгаврыг биелүүлэх 14 хоногийн хугацаа хангагдахгүй байх нөхцөлийг үүсгэж байна.

Иймд захиалагч нь төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээний ажил гүйцэтгэх гэрээний хугацааг гүйцэтгэгч худалдан авах ажиллагааны шалгаруулалтад оролцохдоо төлөвлөсөн календарчилсан графикт хугацаагаар, санхүүжилт олгох хугацааг холбогдох хууль, журамд заасан хугацаагаар зааглаж тогтоож өгөх нь зүйтэй гэж үзэж байна.

Барилга байгууламж ашиглалтад оруулах комисс үүрэг даалгавраар хүлээн авсан төсөл, арга хэмжээ.

1. Биндэр сумын 200 хүүхдийн цэцэрлэгийн барилгын ажлыг гүйцэтгэх гэрээг 2022 оны 4 сарын 7-ны өдөр эхэлж, 2023 оны 10 сарын 2-ны өдөр дуусгахаар байгуулсан боловч Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс нь Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах дүгнэлтийг 2023 оны 12 сарын 20-ны өдөр гаргасан байна. Цэцэрлэгийн барилгыг ашиглалтад оруулах комиссоос өгсөн үүрэг даалгаврын биелэлтээс гадна метал фасадны силикон 2 газар дутуу хийгдсэн, аваарын хаалганы дулаалга хийгдээгүй байна.

Зураг 2. Биндэр сумын 200 хүүхдийн цэцэрлэгийн барилгын зураг



2. Цэнхэрмандал сумын голын усны урсцыг сайжруулах усан сангийн ажил гүйцэтгэх гэрээг 2024 оны 6 сарын 26-ны өдөр эхэлж 8 сарын 19-ний өдөр дуусгахаар байгуулж, улмаар 2024 оны 12 сарын 30 хүртэл сунгасан байна. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс 2024 оны 10 сарын 25-ны өдөр ажиллаж үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад хүлээн авсан боловч талбарт ажиллах үеийн нөхцөл байдлаар далангийн бетон цутгалт хагарсан, шороон даланг тэгшлээгүй, усны урсгал өөрчилсөн сувгийг бүрэн битүүлээгүй байна.

Зураг 3. Хужхан гол усны урсац сайжруулах усан сангийн зураг



3. Өмнөдэлгэр сумын 640 хүүхдийн сургуулийн барилгын ариун цэврийн 2 суултуур хийгдээгүй, гадна бохирын шугамд хөдөлөлт үүссэн байна.

4. Биндэр сумын төвийн шинэчлэл төсөл арга хэмжээний нэмэлт гэрээг ГНАГ-2023/15-ШТА/НА “Улсын төсвөөс санхүүжүүлж хэрэгжүүлэхээр төсвийн хуульд тусгаж баталсан төсөл, арга хэмжээний төсөвт өртөгийн нэмэгдэл зардалд дүгнэлт гаргах” аудитын тайланг үндэслэн, аймгийн дэд бүтцийн зөвлөлийн хурлын шийдвэрээр 2024 оны 5 сарын 1-нд байгуулсан байна. Тус ажлын хүрээнд Биндэр суманд хийгдсэн Цэвэрлэх байгууламжийн туршилт тохируулгын ажлыг 2024 оны 5 сарын 20-оос 6 сарын 15-ны хооронд хийж гүйцэтгэхээр гүйцэтгэгч Монгол дайвин ХХК нь албан бичгээр баталгаа гаргасан боловч одоог хүртэл гүйцэтгээгүй, тухайн ажлын хүрээнд хийгдэх биологийн аргаар цэвэрлэх бактер хийгдээгүй байна.

5. Хэрлэн сумын гэр хорооллын инженерийн шугам сүлжээний ажлын 1, 2 дугаар багцын ажлыг гүйцэтгэгч Солармэд Монгол ХХК нь дулаан, цэвэр усны худаг 168, бохир усны худаг 504, Комфорт импэкс ХХК нь 168 ширхэг худаг хийж гүйцэтгэснээс бохир усны 190 худгийн өндөр болон тагны суурийг янзалсан байна. Үлдсэн бохир усны 314 худгаас газрын түвшнээс өндөр гарсан, үерийн усны улмаас газрын түвшингээс доош суусан худгуудыг гэрээний хугацаанд засварлаагүй байна.

Мөн тус арга хэмжээний хүрээнд бохир, дулааны шугамын ухсан шуудуу, нүхийг 2021 оны 12 сарын 27-ны өдөр магадлалаар баталгаажсан Хэнтий аймаг, Хэрлэн сумын 1-р багийн гэр хорооллын айл өрхийг инженерийн шугам сүлжээнд холбох барилга угсралтын ажлын төсөвт тусгагдсан ургамалт өнгөн хөрсөөр хучих ажлыг хийсэн эсэхийг нотолж чадахгүй байгаа бөгөөд мэргэжлийн шинжээч ажиллуулж тус ажлыг хийгдсэн эсэхийг тодорхойлох шаардлагатай байна.

Зураг 4. Хэрлэн сумын гэр хорооллын инженерийн шугам сүлжээний ажлын зураг



6. Хатуу хучилттай авто зам, 4.1 км /Хэнтий, Батноров сум, Бэрх тосгон/ төсөл, арга хэмжээний хэрэгжих хугацаа 2026 он хүртэл боловч үүрэг даалгаврын биелэлтээр авто замын ажлыг барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс хүлээн авсан байна. Тус төсөл, арга хэмжээний 1000 м явган хүний замын ажил 2025 онд хийгдэхээр үлдсэн байна.

Зураг 5. Бэрх дотор 4.1 км замын зураг



Гэрээний хугацаанд бүрэн дуусаагүй төсөл арга хэмжээ.

1. Мөрөн голын усны урсцыг сайжруулах усан сан хийх ажлын гэрээг 2024 оны 6 сарын 14-ны өдөр байгуулж 8 сарын 26-нд дуусах байсныг хур тунадас ихтэй нөхцөл байдлаас шалтгаалан ажил эхлээгүй байгаатай холбогдуулан аймгийн дэд бүтцийн зөвлөлийн хурлын шийдвэрээр 2024 оны 11 сарын 25-нд дуусгахаар нэмэлт гэрээ байгуулсан боловч гэрээний хугацаанд ажлаа дуусгаагүй байна.

Зураг 6. Мөрөн гол усны урсац сайжруулах усан сангийн зураг



Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төслийн хүрээнд олгогдсон хөдөө аж ахуйн том оврын 9, жижиг оврын 3 нийт 12 тракторыг сумд хүлээн авч нягтлан бодох бүртгэлд тусгасан байна.

Биндэр суманд олгосон 122 сая төгрөгийн өртөгтэй 1 трактор хэнд байгаа нь тодорхойгүй зөрчил илэрснийг аудитын явцад тодорхойлж зөрлийг арилгасан.

“Шинэ хөдөө” төслийн 658 сая төгрөгийн дагалдах бусад тоног төхөөрөмж аймгийн нөөцийн хашаанд хадгалагдаж байгаа нь төсвийн хөрөнгө оруулалтын хүрээнд бий болсон тоног төхөөрөмжийн үр өгөөж буурах, үрэгдэх эрсдэлтэй тул холбогдох сумдад хүлээлгэн өгөх ажлыг зохион байгуулж ажиллах шаардлагатай байна.

Зураг 7. Шинэ хөдөө төслийн тоног төхөөрөмжийн зураг



Гэрээнд тусгаагүй нөхцөлөөр гэрээг сунгасан.

Мөрөнгийн голын урсац сайжруулах усан сан, гэр хорооллын инженерийн шугам сүлжээ, шинэ хөдөө төсөл, Биндэр сумын төвийн шинэчлэлийн ажлууд дээр дэд бүтцийн зөвлөлийн шийдвэрээр, Биндэр сумын 200 хүүхдийн цэцэрлэгийн барилгын нэмэлт ажлын магадлагдсан зураг төсөвтэй холбогдуулан, гүйцэтгэгч байгууллагын хүсэлтээр Өмнөдэлгэр сумын 640 суудалтай сургуулийн барилгын ажлын гэрээг сунгасан байна.

Дэд бүтцийн зөвлөлийн шийдвэр болон гүйцэтгэгчийн хүсэлтээр 5 гэрээг сунгасан нь захиалагч, гүйцэтгэгч нарын хооронд байгуулсан ажил гүйцэтгэх гэрээний гэрээг сунгах нөхцөлд тусгагдаагүй байна.

Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4.8.29.-д “Төсөл, арга хэмжээний эцсийн буюу бүрэн санхүүжилтийн хүсэлтэд гэрээг дүгнэсэн байх” заалтын хүрээнд эрх шилжүүлсэн хэрэгжүүлж гэрээний хугацаа дууссан 13 төсөл, арга хэмжээнээс гэрээг дүгнэсэн 8, дүгнээгүй 1, дүгнэсэн эсэх нь тодорхойгүй 4 төсөл арга хэмжээ байна.

Хүснэгт 6. Гэрээ дүгнэсэн эсэх жагсаалт

№	Төсөл, арга хэмжээ	Гэрээ дүгнэсэн эсэх	Комисс хүлээн авсан эсэх	Тайлбар
1	Цэнхэр, Мөрөнгийн голын урсац сайжруулах усан сан /Хэнтий/	Үгүй	Багц-2 хүлээн авсан	Багц 1 бүрэн хэрэгжиж дуусаагүй. Багц-2 Цэнхэрийн голын усан санг Үүрэг даалгаврын биелэлтээр хүлээн авсан
2	Иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилга /Хэнтий, Мөрөн сум/	Үгүй	Үгүй	Хугацаа болоогүй
3	Үүрэн холбооны сүлжээ /Хэнтий, Норовлин, Галшар, Батноров, Биндэр, Баян-Адарга, Дадал, Дархан, Баянмөнх сум/	Үгүй	Үгүй	Хугацаа болоогүй
4	Цаг уурын өртөөний барилгын их засвар /Хэнтий, Дэлгэрхаан, Хэрлэн Баян-Улаан/	Үгүй	Тийм	Гэрээ дүгнэсэн эсэх тодорхойгүй
5	Цаг уурын өртөөний барилгын их засвар /Хэнтий, Өмнөдэлгэр/	Үгүй	Тийм	Гэрээ дүгнэсэн эсэх тодорхойгүй
6	Хамгаалалтын захиргааны авто гаражийн ажил /Гутайн даваа-Хөмүүл голын эхийн БЦГ/	Үгүй	Тийм	Хэрэгжээгүй
7	Хэнтий аймгийн цагдаагийн газрын өргөтгөлийн барилгын их засвар	Үгүй	Тийм	Гэрээ дүгнэсэн эсэх тодорхойгүй
8	Хамгаалалтын захиргааны барилгын засвар /Онон Балжийн БЦГ/	Үгүй	Тийм	Гэрээ дүгнэсэн эсэх тодорхойгүй

3.3 Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс нь хөрөнгө оруулалтын 6 төсөл, арга хэмжээний үүрэг даалгаврын биелэлтийг хяналгүй хууль, дүрмийг зөрчин хүлээж авсан байна.

Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс нь “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрмийн” 8.2.2.⁴-ийг биелүүлэлгүй улсын төсвийн хөрөнгө

⁴ 8.2.2. энэ дүрмийн 5.1, 6.1-д заасан шаардлага хангаагүй, 8.1-д заасан хугацаанд үүрэг даалгаврын биелэлт хангагдаагүй тохиолдолд татгалзсан дүгнэлт.

оруулалтаар хэрэгжүүлсэн 6 төсөл, арга хэмжээг бүрэн дуусаагүй байхад үүрэг даалгаврын биелэлтийг хяналгүй ашиглалтад оруулах дүгнэлт гаргасан байна.

Хүснэгт 7. Үүрэг даалгаврын биелэлтийг хяналгүй хүлээн авсан төсөл, арга хэмжээний жагсаалт

№	Төсөл, арга хэмжээ	Дүгнэлтийн дугаар	Тайлбар
1	Цэцэрлэгийн барилга, 200 ор /Хэнтий, Биндэр сум/	2023.12.20 124/2023	Үүрэг даалгаврын биелэлтээр комисс хүлээн авсан
2	Сургуулийн барилга, 640 суудал /Хэнтий, Өмнөдэлгэр сум/	2023.12.14 БУА-102/2023	Үүрэг даалгаврын биелэлтээр комисс хүлээн авсан
3	Хатуу хучилттай авто зам, 4.1 км /Хэнтий, Батноров сум, Бэрх тосгон/	2024.11.06 61/2024	Үүрэг даалгаврын биелэлтээр комисс хүлээн авсан
4	Цэнхэр /Хужхан/ голын урсац сайжруулах усан сан	2024.10.29 Хөв-47/2024	Үүрэг даалгаврын биелэлтээр комисс хүлээн авсан
5	Сумын төвийн шинэчлэл /Хэнтий, Биндэр сум/	80/2019	Үүрэг даалгаврын биелэлтээр комисс хүлээн авсан
6	Гэр хорооллын инженерийн шугам сүлжээ /Хэнтий, Хэрлэн сум/	2024.10.30 ИШС-60/2024	Үүрэг даалгаврын биелэлтээр комисс хүлээн авсан


Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс нь Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолын хавсралтаар баталсан Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрмийн 5 дахь хэсэгт заасан чиг үүргийн дагуу үүрэг даалгаврын биелэлтийг хянах ажлыг хэрэгжүүлээгүй байна.

Гэр хорооллын инженерийн шугам сүлжээ /Хэнтий, Хэрлэн сум/ төсөл, арга хэмжээг хүлээн авахдаа ажлын батлагдсан төсөвт тусгагдсан ухсан шуудуу, нүхийг ургамалт өнгөн хөрсөөр хучих ажлыг гүйцэтгэсэн эсэхийг хянаж хүлээн аваагүй байна.

Дүрслэл 4. Хэрлэн сумын 1, 2 дугаар багийн иргэдтэй хийсэн үр дүн.

Инженерийн шугам сүлжээний ажил таны амьдрах орчин, нөхцөлөө сайжруулахад хэрэг тусаа өгөх ажил болж чадсан уу?

Инженерийн шугам, сүлжээний ажлыг гүйцэтгэж дууссаны дараа гудамж, зам талбайг өмнөх байдалд нь оруулж нөхөн сэргээсэн үү?



Хэрлэн сумын инженерийн шугам сүлжээний ажил нь судалгаанд хамрагдсан 51 иргэний 43 буюу 84.3% нь амьдрах орчин нөхцөлөө сайжруулахад хэрэг тусаа өгөх ажил гэж дүгнэсэн бол 39.2% нь нөхөн сэргээлтийн ажлыг хангалтгүй амьдрах орчныг хэвийн байдалд оруулаагүй гэж үзжээ.

3.4 Хэрэгжиж дууссан төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон 30.5 тэрбум төгрөгийн хөрөнгийг бүртгэлд тусгаагүй байна.

Гэр хорооллын инженерийн шугам сүлжээ Багц-1, Багц-2 төсөл, арга хэмжээг бүртгэлд тусгах тухай албан бичгийг 2025 оны 1 сарын 7-нд албан байгууллагуудад хүргүүлсэн боловч Хэнтий Ус ХХК-ийн 2025 оны 1 сарын 21-ний 18 тоот албан бичгээр улсын комиссын акт дээр гарын үсэг зураагүй тул хөрөнгөд бүртгэх боломжгүй тухай хариуг хүргүүлсэн байна.

Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын гишүүд үүрэг даалгавраар хүлээн авах санал илэрхийлж биелэлтийг дулааны улиралд хийлгэхээр биелэлт хэсэгт тусган гарын үсэг зурсан байна. Аймгийн Засаг даргын 2021 оны 12 сарын 20-ны өдрийн А/630 тоот Барилга байгууламжийг ашиглалтад оруулах үйл ажиллагааны тухай захирамжийн нэгдүгээр хавсралтаар баталсан комиссын бүрэлдэхүүнд инженерийн хангамжийн байгууллагын төлөөлөл, ашиглалт хариуцсан байгууллагыг төлөөлж Хэнтий Ус ХХК-ийн ерөнхий инженер болон УХАТ-ын инженер нар ажиллаж газрын үсэг зурж баталгаажуулсан байна.

“Шинэ хөдөө” төслийн 658.0 сая төгрөгийн 23 нэр төрлийн 27 тоног төхөөрөмжийг 2024 оны 9 болон 10 сард техникийн шаардлага хангахгүй шалтгаанаар 2 удаа буцаасан бөгөөд 12 сарын 30 өдөр шаардлага хангасан тоног төхөөрөмжийг хүлээн авснаас шалтгаалж холбогдох 9 сумдад хүлээлгэж өгөх ажил хийгдээгүй байна.

Дээрх 2 нөхцөлөөс шалтгаалж 30.5 тэрбум төгрөгөөр санхүүжүүлсэн 1 инженерийн шугам сүлжээ, 1 тоног төхөөрөмжийн ажлыг нягтлан бодох бүртгэлд тусгаагүй байна.


Тус төсөл арга хэмжээг данс бүртгэлд тусгаагүй зөрчлийг яаралтай арилгах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

“Шинэ Хөдөө” төслөөр олгосон тоног төхөөрөмжийг хүлээн авснаас хойш зориулалтын дагуу огт ашиглаагүй, Гэр хорооллын инженерийн шугам сүлжээний ажлын 1, 2 дугаар багцын ажил дууссан боловч шугам сүлжээний туршилт, тохируулгын ажил хийгдээгүй, хэрэглэгч холбогдоогүй шалтгаанаар ашиглалтгүй байна.


Дүрслэл 5. Иргэдээс авсан санал асуулгын дүн

Танай гэр бүл инженерийн шугамд холбогдох боломжтой юу?

Мэргэжлийн байгууллагаас тогтоосон холболтын өртөг / 1 метр нь 1200 000 төгрөг/-өөр гэр байшингаа холбох боломжтой гэж үзэж байна уу?



Танай өрхийн орлого сард дунджаар хэдэн төгрөг вэ?



Хэрлэн сумын 1, 2 дугаар багийн 51 иргэн судалгаанд хамрагдсан бөгөөд 60.8% нь 1 сая хүртэл цалин орлоготой, 35.3 хувь нь 1.2 сая төгрөгөөр холболт хийлгэх боломжгүй, 37.2% нь бусад болон хөнгөлөлттэй зээл, төлбөрийн уян хатан нөхцөл санал болговол холбогдох боломжтой дүн гарсан.

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ:



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

Залуучуудын гудамж-01, Баянмөнх баг, Хэрлэн сум,
Чингис хот, Хэнтий аймаг, 23117
Утас/Факс: (976) 7056 2412
Цахим шуудан: infoazdtg@khentii.gov.mn

2025. 04. 18 № 5/853

танай _____ -ны № _____ -т

**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ**

ХЭА-2025/06-22-ШТА-ГА кодтой "Орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт"-д хийсэн гүйцэтгэлийн аудит, ХЭА-2025/06-22-ШТА-НА кодтой "Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт"-д хийсэн нийцлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Тайлангийн төсөлд тусгах саналгүй болно.

ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ,
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ _____ Д.БАЯРХҮҮ



231071112

Нийцлийн аудитаар нийт зөрчил арилгах 3 зөвлөмжийг аймгийн Засаг даргын тамгын газар, Газрын харилцаа барилга хот байгуулалтын газарт, зөрчлийг таслан зогсоох 166.6 сая төгрөгийн 2 албан шаардлагыг аймгийн Засаг даргын Тамгын газар, Газрын харилцаа барилга хот байгуулалтын газарт тус тус хүргүүлж, хөндлөнгийн шинжээч ажиллуулах, төсвийн ерөнхийлөн захирагч нар Монгол Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөтэй уялдуулж хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөх тухай зөвлөмж хүргүүлэх 2 саналыг Үндэсний аудитын газарт хүргүүллээ.

ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна.

- Комиссын гишүүд нь Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрмийн 8.2.2-д заасныг зөрчиж 6 төсөл, арга хэмжээг үүрэг даалгаврын хэрэгжилтийг хяналгүй ашиглалтад оруулах дүгнэлт гаргасан байна.
- ТЕЗ сайд нар нь төлөвлөлтийн шаардлага хангаагүй 4, Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөтэй нийцээгүй 8, эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг бүрэн тооцоогүй 2 нийт давхардсанаар 8 төсөл арга хэмжээг, аймгийн Засаг дарга нь төлөвлөлтийн шаардлага хангаагүй 1, улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөтэй нийцээгүй 1 арга хэмжээг тус тус төлөвлөж хэрэгжүүлсэн байна.
- Аймгийн ТЕЗ нь Төсвийн тухай хуулийн 7.7 дахь заалт, Барилга хот байгуулалтын сайдын “Барилгын захиалагчийн хяналтын талаар авах зарим арга хэмжээний тухай” 2022 оны 83 дугаар тушаалын 2.1.4-д заасныг зөрчин хөрөнгө оруулалтын олгогдоогүй үлдээдлийг аймгийн ерөнхий данс руу төвлөрүүлсэн байна.
- ГХБХБГ нь барилгын ажлын календарчилсан графикт хугацааны дагуу захиалагчийн хяналтыг бүрэн хэрэгжүүлж ажиллах шаардлагатай байна.
- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг батлах, эрх шилжүүлэх, худалдан авах ажиллагааны журмыг сонгох, сонгон шалгаруулах үйл ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулсан байна.
- Захиалагч, гүйцэтгэгч нарын хооронд байгуулсан ажил гүйцэтгэх гэрээний гэрээг сунгах нөхцөлд тусгаагдаагүй дэд бүтцийн зөвлөлийн шийдвэр болон гүйцэтгэгчийн хүсэлтээр 5 гэрээг сунгасан байна.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүнд үндэслэн дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

Аймгийн Засаг дарга Д.Аюурбунь-д

- *Хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон барилга байгууламж, тоног төхөөрөмжийг үр дүнтэй бүрэн ашиглах талаар холбогдох арга хэмжээг авч ажиллах.*
- *Гэрээнд тусгагдсан нөхцөлөөс бусад шалтгаанаар гэрээг сунгахгүй байх арга хэмжээг хэрэгжүүлэх*

Аймгийн Газрын харилцаа барилга хот байгуулалтын хэлтсийн дарга Б.Сүнгээ-д

- *Захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэхдээ гүйцэтгэгчийн барилгын ажлын календарчилсан графикт хугацааг мөрдүүлж, хяналт тавьж ажиллах*

ҮАГ-ААР ДАМЖУУЛАН УЛАМЖИЛЖ САНГИЙН ЯАМАНД ТАВИХ САНАЛ:

- Төсвийн ерөнхийлөн захирагчаас орон нутагт эрх шилжүүлэн хэрэгжүүлсэн Гэр хорооллын инженерийн шугам сүлжээний ажил /Хэрлэн сум 1, 2-р багц/-ын шугамыг ургамалт өнгөн хөрсөөр буцаан хучсан эсэх нь аудитын явцад нотлогдохгүй байгаа тул хөндлөнгийн шинжээч ажиллуулах.
- Төсвийн ерөнхийлөн захирагч /сайд нар/-ийн багцад тусгагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөтэй уялдуулж, төлөвлөлтийн шаардлага хангасан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөх талаар зөвлөмж хүргүүлэх.

Аудитын зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх ажлыг төлөвлөгөөг “Төрийн аудитын тухай” хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасан хугацаанд, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг тогтоосон хугацаанд ирүүлнэ үү.

АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН БҮРТГЭЛ

Аудитын нэр: "Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт"
Аудитын код: ХЭА-2025/06-22-ШТА-НА

Байгууллагын нэр: Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газар

№	Аудитын чиглэл, асуулт	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн (төгрөг)	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Шалгагдагч байгууллагын санал, тайлбар	Гаргасан шийдвэр
Аудитын дэд зорилт А. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд хууль, журамд заасан шаардлага хангасан төсөл, арга хэмжээг төлөвлөсөн үү?						
1.1. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөтэй уялдуулж төлөвлөсөн үү?						
1	1.1.1 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөтэй уялдуулж төлөвлөсөн үү?	Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд тусгагдаагүй Мөрөн сумын иргэдэд үйлчлэх барилга, Цэнхэр, Мөрөнгийн голын урсцын сайжруулах усан сан, Үүрэн холбооны сүлжээ, Шинэ хөдөө төсөл, Цагдаагийн газрын өргөтгөлийн барилгын их засвар, Онон балжийн БЦГ-ын хамгаалалтын захиргааны засвар, Гутайн даваа-Хөмүүл голын эхийн БЦГ-ын авто гражийн ажил зэрэг ний 9 төсөл арга хэмжээг шинээр төлөвлөж хэрэгжүүлсэн байна. Хэнтий аймгаас хүргүүлсэн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн саналд тусгагдаагүй төсөл арга хэмжээг салбарын сайдын багцаас орон нутагт эрх шилжүүлэн хэрэгжүүлсэн байна.		YAГ-т САНАЛ: Сайд нар улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөтэй уялдуулж, төлөвлөлтийн шаардлага хангасан хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг төлөвлөх	Санаа байхгүй	САНАА УЛАМЖЛАХ
2	1.2.1 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг аргачлалын дагуу үнэлж эрэмбэлэн эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг тооцож төлөвлөсөн үү?	Барилгын тухай хуулийн 4.1.26-д "гүйцэтгэлийн зураг" гэж батлагдсан зураг төслийг зохиогчийн зөвшөөрлөөр өөрчилж, эрх бүхий этгээдийн баталгаажуулсан барилгын ажлын зураг төслийг Засгийн газрын 2019 оны 108 дугаар тогтоолоор батлагдсан "Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм"-ийн 3.6. "Барилгын тухай хуулийн 4.1.27-д заасан загвар зургийг архитектур төлөвлөлтийн даалгавар болон зураг төслийн даалгаврыг үндэслэн боловсруулах бөгөөд аймаг, нийслэлийн ерөнхий архитектор батална" гэж заасны дагуу төсөл, арга хэмжээний ажлын тоо хэмжээг тодорхойлоогүй, зардлын тооцоолол хийгдээгүй, магадлагдсан төсөвгүй 5 төсөл, арга хэмжээ байна.		YAГ-т САНАЛ: Сайд нар улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөтэй уялдуулж, төлөвлөлтийн шаардлага хангасан хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг төлөвлөх	Санаа байхгүй	САНАА УЛАМЖЛАХ
Дэд зорилт В. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хууль журмын дагуу санхүүжүүлж, хугацаанд нь гүйцэтгүүлэн бүртгэлд тусгасан үү?						
3.1. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг ажлын гүйцэтгэлд үндэслэн хууль журмын дагуу санхүүжүүлсэн үү?						
3	3.1.2. Санхүүжилтийг хугацаанд нь бүрэн шилжүүлсэн үү?	Сургуулийн барилга, 640 суудал /Хэнтий, Өмнөдэлгэр сум/ -ийн захиалагчийн хяналтын 5,187,478 төгрөг, Цэнхэр, Мөрөнгийн голын урсац сайжруулах усан сан /Хэнтий/ зохиогчийн хяналтын 1,837,363 төгрөг, захиалагчийн хяналтын 978,763 төгрөг, Хатуу хучилттай авто зам, 4.1 км /Хэнтий, Батноров сум, Бэрх тосгон/-ийн захиалагчийн хяналтын 78,830,094 төгрөг, Гэр хорооллын инженерийн шугам сүлжээ /Хэнтий, Хэрлэн сум/-ний захиалагчийн хяналтын 81,639,171 төгрөгийн зардлыг аймгийн нэр заагдаагүй бусад орлогын дансанд төвлөрүүлсэн байна		АЛБАН ШААРДЛАГА 2: хяналтын зардлыг зориулалт бусаар аймгийн нэр заагдаагүй бусад орлогын данс руу төвлөрүүлсэн зөрчлийг таслан зогсоож, барилга байгууламж ашиглалтад оруулах комиссын дүгнэлтээр хүлээн авсан төсөл арга хэмжээний захиалагчийн хяналтын зардлыг хэрэгжүүлэгч байгууллагад шилжүүлэх.	Санаа байхгүй	АЛБАН ШААРДЛАГА
3.2. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөсөн хугацаанд хэрэгжүүлж, гэрээг дүгнэсэн үү?						
4		Биндэр сумын 200 хүүхдийн цэцэрлэгийн барилгад барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссоос өгсөн үүрэг даалгаврын биелэлтээс гадна метал фасадны силикон 2 газар дутуу хийгдсэн, аваарын хаалганы дулаалга хийгдээгүй байна.		ЗӨВЛӨМЖ 3: Захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэхдээ гүйцэтгэгч худалдан авах ажиллагааны тендерт оролцохдоо төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн хугацааг мөрдүүлэх	Санаа байхгүй	ЗӨВЛӨМЖ өгөх

5	Мөрөн голын усны урсацыг сайжруулах усан сан хийх ажлын гэрээг 2024 оны 6 сарын 14-ны өдрөөс 8 сарын 26-ны өдөр дуусах байсныг хур тунадас ихтэй нөхцөл байдлаас шалтгаалан ажил эхлээгүй байгаатай холбогдуулан аймгийн дэд бүтцийн зөвлөлийн хурлын шийдвэрээр 2024 оны 11 сарын 25-нд дуусгахаар нэмэлт гэрээ байгуулсан боловч гэрээний хугацаанд ажлаа дуусгаагүй байна. Улсын комисс ажиллах хүсэлтийг гүйцэтгэгч Нутгийн баруун мод ХХК-аас ГХБХБГ-т хүргүүлсэн боловч гүйцэтгэл хангалтгүй шалтгаанаар ГХБХБГ, Байгаль орчны газраас улсын комисст ажиллахаас татгалзсан байна.	ЗӨВЛӨМЖ 3: Захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэхдээ гүйцэтгэгч худалдан авах ажиллагааны тендерт оролцохдоо төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн хугацааг мөрдүүлэх	Санаа байхгүй	Зөвлөмж өгөх
6	Цэнхэрмандал сумын голын усны урсацыг сайжруулах усан сангийн ажил гүйцэтгэх гэрээг 2024 оны 6 сарын 26-ны өдөр эхэлж 8 сарын 19-ний өдөр дуусгахаар байгуулж гэрээг 2024 оны 12 сарын 30 хүртэл сунгасан байна. Улсын комисс ажиллуулах мэдэгдлийг гүйцэтгэгч Гидро фонтан ХХК 2024 оны 10 сарын 21-ны өдөр хүргүүлж улсын комисс 2024 оны 10 сарын 25-ны өдөр ажиллаж үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад хүлээн авсан боловч талбарт ажиллах үеийн нөхцөл байдлаар далангийн бетон цутгалт хагарсан, шороон даланг тэгшлээгүй, усны урсгал өөрчилсөн голидролыг бүрэн битүүлээгүй орхисон байна.	ЗӨВЛӨМЖ 3: Захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэхдээ гүйцэтгэгч худалдан авах ажиллагааны тендерт оролцохдоо төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн хугацааг мөрдүүлэх	Санаа байхгүй	Зөвлөмж өгөх
7	Өмнөдэлгэр сумын 640 хүүхдийн сургуулийн барилгын ариун цэврийн 2 суултуур хийгдээгүй, гадна бохирын шугмын налуу алдагдаж бохирын шугам хөлдсөн, гүйцэтгэгчийн хүсэлтээр ажил гүйцэтгэх гэрээг сунгасан.	ЗӨВЛӨМЖ 3: Захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэхдээ гүйцэтгэгч худалдан авах ажиллагааны тендерт оролцохдоо төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн хугацааг мөрдүүлэх	Санаа байхгүй	Зөвлөмж өгөх
8	3.2.1 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ гэрээний хугацаанд бүрэн хэрэгжсэн үү? 2014 онд хийгдэж эхэлсэн Биндэр сумын төвийн шинэчлэл төсөл арга хэмжээний цэвэрлэх байгууламжийн туршилт тохируулгын ажлыг 2024 оны 5 сарын 20-оос 6 сарын 15-ны хооронд хийж гүйцэтгэхээр гүйцэтгэгч Монгол дайвин ХХК нь албан бичгээр баталгаа гаргасан боловч талбарт ажиллах үед цэвэрлэх байгууламжийн туршилт, тохируулгын ажлыг одоог хүртэл гүйцэтгээгүй байгаа бөгөөд уг ажлын хүрээнд хийгдэх бактерийг хийгээгүй зөрчил илэрсэн.	ЗӨВЛӨМЖ 3: Захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэхдээ гүйцэтгэгч худалдан авах ажиллагааны тендерт оролцохдоо төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн хугацааг мөрдүүлэх	Санаа байхгүй	Зөвлөмж өгөх
9	Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төслийн хүрээнд олгогдсон хөдөө аж ахуйн 9 тракторыг сумд хүлээн авч нягтлан бодох бүртгэлд тусгасан байна. Дагалдах бусад тоног төхөөрөмжийг сумдууд тээвэрлэх тээврийн хэрэгсэл, хадгалах байр зэргээс шалтгаалан хүлээн аваагүй байна. Биндэр сумад олгосон 122 сая төгрөгийн өртөгтэй 1 тракторийн эзэмшигч тодорхойгүй зөрчил илэрсэн.	ЗӨВЛӨМЖ 3: Захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэхдээ гүйцэтгэгч худалдан авах ажиллагааны тендерт оролцохдоо төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн хугацааг мөрдүүлэх	Санаа байхгүй	Зөвлөмж өгөх
10	Цэнхэр, Мөрөнгийн голын урсац сайжруулах усан сан, гэр хорооллын инженерийн шугам сүлжээ, шинэ хөдөө төсөл, Биндэр сумын төвийн шинэчлэлийн ажлууд дээр дэд бүтцийн зөвлөлийн шийдвэрээр, Биндэр сумын 200 хүүхдийн цэцэрлэгийн барилгын нэмэлт ажлын магадлагдсан зураг төсөвтэй холбогдуулан, гүйцэтгэгч байгууллагын хүсэлтээр Өмнөдэлгэр сумын 640 суудалтай сургуулийн барилгын ажлын гэрээг тус тус сунгасан байна.	ЗӨВЛӨМЖ 2: Гэрээнд тусгагдсан нөхцөлөөс бусад шалтгаанаар гэрээг сунгахгүй байх арга хэмжээг хэрэгжүүлэх	Санаа байхгүй	Зөвлөмж өгөх
11	Хэрлэн сумын гэр хорооллын инженерийн шугам сүлжээний ажлын 1, 2 дугаар багцын ажлыг гүйцэтгэгч Солармэд Монгол ХХК нь дулаан, цэвэр усны худаг 168, бохир усны худаг 504, Комфорт импэкс ХХК нь 168 ширхэг худаг хийж гүйцэтгэснээс бохир усны 190 худгийн өндөр болон тагны суурийг янзалсан байна. Үлдсэн 314 худгаас газрын түвшнээс өндөр гарсан, үерийн усны улмаас газрын түвшингээс доош суусан худгуудыг гэрээний хугацаанд засварлаагүй байна.	ҮАГ-Т САНАЛ: Хөндлөнгийн шинжээч ажиллуулахаар, ашиглалтад хүлээн авсан гэр хорооллын инженерийн шугам, сүлжээний ажлын худгийн зөрчлийг гүйцэтгэгч байгууллагаар засварлуулах.	Санаа байхгүй	САНАЛ Уламжлах
3.3. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг зураг төсөв, техникийн тодорхойлолтын дагуу гүйцэтгүүлж, холбогдох хууль журамд нийцүүлэн хүлээн авсан үү?				

12	3.3.2 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг холбогдох хууль журамд нийцүүлэн хүлээн авсан уу?	Биндэр сумын 200 хүүхдийн цэцэрлэгийн барилга, Цэнхэр, Мөрөнгийн голын усны урсцыг сайжруулах усан сан, Гэр хорооллын инженерийн шугам сүлжээ, Сургуулийн барилга, 640 суудал /Хэнтий, Өмнөдэлгэр сум/, Хатуу хучилттай авто зам, 4.1 км /Хэнтий, Батноров сум, Бэрх тосгон/, Сумын төвийн шинэчлэл /Хэнтий, Биндэр сум/ ажлууд нь Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрмийн 7.6. "Комисс ажилласны дараа комиссын гишүүд өгсөн санал, үүрэг даалгаврын биелэлтийг шалгаж, биелэлт хангагдсан тохиолдолд энэ дүрмийн 4 дүгээр хавсралтад заасан үүрэг даалгаврын биелэлтийн хуудсанд гарын үсэг зурж баталгаажуулна", 8.2.2. "энэ дүрмийн 5.1, 6.1-д заасан шаардлага хангаагүй, 8.1-д заасан хугацаанд үүрэг даалгаврын биелэлт хангагдаагүй тохиолдолд татгалзсан дүгнэлт" заалтыг зөрчсөн байна.	АЛБАН ШААРДЛАГА 1: Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын ажиллах журмыг мөрдөж, зөрчлийг таслан зогсоох	санал байхгүй	АЛБАН ШААРДЛАГА
3.4. Хэрэгжиж дууссан төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон хөрөнгийг бүртгэлд тусгаж, зориулалтын дагуу ашиглаж байна уу?					
13	3.4. Хэрэгжиж дууссан төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон хөрөнгийг бүртгэлд тусгаж, зориулалтын дагуу ашиглаж байна уу?	"Шинэ хөдөө" төслийн 658.0 сая төгрөгийн 23 нэр төрлийн 27 тоног төхөөрөмжийг 2024 оны 9 болон 10 сард техникийн шаардлага хангахгүй шалтгаанаар 2 удаа буцаасан бөгөөд 12 сарын 30 өдөр шаардлага хангасан тоног төхөөрөмжийг хүлээн авснаас шалтгаалж холбогдох 9 сумдад хүлээлгэж өгөх ажил хийгдээгүй байна. Хэрлэн сумын гэр хорооллын инженерийн шугам сүлжээний ажлыг барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс хүлээн авсан боловч туршилт тохируулгын ажил хийгдээгүй, хэрэглэгч холбоогдоогүй шалтгаанаар ашиглалтгүй, мөн хөрөнгийн бүртгэлд тусгаагүй байна.	ЗӨВЛӨМЖ 1: Хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон барилга байгууламж, тоног төхөөрөмжийг үр дүнтэй бүрэн ашиглах талаар холбогдох арга хэмжээг авч ажиллах.	санал байхгүй	ЗӨВЛӨМЖ ӨГӨХ
		НИЙТ ДҮН	-		

Бэлтгэсэн:


Аудитор:



Т.Алтаншагай

Огноо 2025.04.09

Ахлах аудитор:




Д.Эрдэнэбилэг

Огноо 2025-04-05

Анхан шатанд хянасан:

Аудитын менежер:



Д.Оюунтуяа

Огноо 2025-04-09

Хоёр дахь шатанд хянасан:

Дарга, тэргүүлэх аудитор:




Ж.Ганбаатар

Огноо 2025-4-9

Танилцсан:


Аймгийн Засаг дарга



Д.Аюурбунь

Огноо 17/6 2025


Аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ-ийн дарга



Д.Баярхүү

Огноо 2025.04.09

Аймгийн ЗДТГ-ын -ын СТСХ-ийн дарга



Н.Үнэнбат

Огноо 09/4/2025.

Аймгийн ГХБХБГ-н дарга



Б.Сүнгээ

Огноо 2025.04.09

Хэнтий аймаг, Хэрлэн сум, 4-р баг,
Аймгийн Засаг даргын Тамгын газрын байр, 3 давхарт
Утас: +976 70562112
И-мэйл хаяг: khentii@audit.gov.mn, Веб сайт: www.audit.mn